



**ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ**

**ӨГӨГДЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН
ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

**Улаанбаатар хот
2026 он**

АГУУЛГА

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	3
ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ	4
ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ	4
3.1. "Зорилгод хүрэх байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэгдэх хуулийн төслийн зохицуулалт:	4
3.2. "Практикт хэрэгжих боломж" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал	6
ДӨРӨВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ	7
4.1. "Зорилгод хүрэх байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:	15
4.2. "Практикт хэрэгжих боломж" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ	20
ТАВ. ҮР ДҮНГ ҮНЭЛСЭН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	30
5.1. Үр дүнг баримтжуулах	30
5.2. Үнэлэх	30
5.3. Зөвлөмж	32
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ	34

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү үнэлгээний ажлын гол зорилго нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтад “энэ хуулийн 17, 18 дугаар зүйлд заасны дагуу хууль тогтоомжийн төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоог хийх;” гэж заасны дагуу Өгөгдлийн тухай хуулийн төслийн зарим зохицуулалт /зүйл, хэсэг, заалт/-д тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн төслийн бичвэрийг ойлгомжтой, хэрэгжих боломжтой, хүлээн зөвшөөрөгдөх байдлаар боловсруулах болон хуулийн төслийн боловсруулалтын чанарыг сайжруулахад чиглэсэн дүгнэлт, зөвлөмж өгөхөд оршино.

Өгөгдлийн тухай хуулийн төсөл /цаашид “хуулийн төсөл” гэх/-ийн зарим зохицуулалтын үр нөлөөг үнэлэхдээ Хууль тогтоомжийн тухай хууль, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын¹ 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-г баримтлан доорх үе шаттайгаар хийв.

- 1.1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
- 1.2. Хуулийн төслөөс үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоох;
- 1.3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
- 1.4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

Үр нөлөөний үнэлгээ хийсэн хуулийн төслийн хувилбарыг энэхүү тайланд хавсаргав.

¹ Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дүгээр тогтоолоор батлагдсан.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ

Энэхүү үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан 6 шалгуур үзүүлэлтээс хуулийн төслийн үр нөлөөг үнэлж, гарах үр дагаврыг урьдчилан тогтоож чадахуйц дараах шалгуур үзүүлэлтүүдийг сонголоо. Үүнд:

- 1.Зорилгод хүрэх байдал;
- 2.Практикт хэрэглэх боломж.

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл болон түүний зорилго нь хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан зорилгын хүрээнд боловсруулагдаж чадсан эсэх болон бодит үндэслэл, шаардлагад нийцэж буй байдал, хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтууд нь төслийн зорилгыг хангахад чиглэсэн бөгөөд түүнд хүргэх боломжтой эсэхийг үнэлнэ. Энэхүү үнэлгээг хийхдээ хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, хуулийн төсөлтэй танилцаж хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагыг судлан үзсэний дагуу хуулийн төслөөс түүний зорилго болон зорилгод хүрэхэд чиглэгдсэн бөгөөд хуулийн зорилгыг тодорхой илэрхийлж чадахуйц арга хэмжээ буюу зохицуулалтыг сонгож авсан болно.

“Практикт хэрэгжих боломж” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зүйл, заалтууд дагаж мөрдөх болон хэрэгжүүлэхэд боломжтойгоор боловсруулагдаж чадсан эсэх, дагаж мөрдөх боломжтой эсэх, тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх субъект, байгууллага нь хэн байх, тэдгээр байгууллагад тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо байгаа эсэхийг үнэлнэ.

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

3.1.“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэгдэх хуулийн төслийн зохицуулалт:

Хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төсөл боловсруулах болсон хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэхийг шалгахын тулд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ шаардлагыг хуулийн төсөлд хэрхэн тусгасныг тогтоох, эдгээр зохицуулалт нь үзэл баримтлалд тодорхойлсон хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэхийг харьцуулан дүгнэж, зарчмын шинжтэй өөрчлөлтийг үнэлэхээр хуулийн төслийн үзэл баримтлалд дурдсан чухал, ач холбогдолтой дараах зүйл, хэсэг, заалтыг сонгон авч хуулийн төслийн зохицуулалтын үр нөлөөг үнэлэхээр тусгалаа:

Хүснэгт 1. Хуулийн төслийн зорилгод хүрэх байдлыг сонгон үнэлэх

Зорилгод хүрэх байдал /Үзэл баримтлалаас/	Сонгосон бүлэг, зүйл, хэсэг, заалт
--	------------------------------------

Өгөгдлийн дэд бүтцийг тодорхойлж, төрийн их өгөгдөл, өгөгдлийн санг мэдээллийн сангийн нэгдсэн ангилал, кодын дагуу үүсгэх, сангаас ашиглах зориулалтаас нь шалтгаалж өгөгдлийг ангилж, хүртээмжтэй ашиглуулах нөхцөлийг бүрдүүлэх.	2 дугаар бүлэг. Өгөгдлийн дэд бүтэц, өгөгдлийн сан
Өгөгдлийн амьдралын мөчлөг буюу өгөгдөл үүсгэх, цуглуулах, ангилах, боловсруулах, ашиглах, солилцох, дамжуулах, хадгалах, нөөцлөх, устгах харилцааг зохицуулах.	3 дугаар бүлэг. Өгөгдлийн амьдралын мөчлөг
Өгөгдлийн харилцаанд оролцогч, тэдгээрийн бүрэн эрх, чиг үүргийг тодорхойлж, өгөгдлийн засаглалын тогтолцоог бэхжүүлэх.	5 дугаар бүлэг. Өгөгдлийн засаглалын тогтолцоо

3.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

Практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн 2 дугаар бүлэгт заасан төрийн их өгөгдлийн дэд бүтцийг бий болгох, өгөгдлийн сан үүсгэх, өгөгдлийн санд тавих шаардлагыг, хуулийн төслийн 4 дүгээр бүлэгт заасан Монгол Улсад дата төвийн үйлчилгээ эрхлэх, уг үйл ажиллагааг эрхлэх этгээдэд дэмжлэг үзүүлэхтэй холбогдсон зохицуулалтуудыг сонгон авч “Практикт хэрэгжих боломж”-ыг тооцсон болно. Сонгосон зүйл заалтуудыг дэлгэрэнгүйг хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 2. Хуулийн төслийн практикт хэрэгжих боломжийг сонгон үнэлэх

Д/д	Практикт хэрэгжих боломж	Сонгосон бүлэг, зүйл, хэсэг, заалт
1	Төрийн их өгөгдлийн дэд бүтэц	Хуулийн төслийн 2 дугаар бүлэг
2	Төрийн их өгөгдөл	
3	Их өгөгдлийн сан болон өгөгдлийн сан үүсгэх, түүнд тавигдах шаардлага	
4	Дата төвийн үйлчилгээ эрхлэх, эрх зүйн баталгаа	Хуулийн төслийн 4 дүгээр бүлэг
5	Хил дамнасан өгөгдлийн урсгал, технологийн зохицуулалтын туршилтын орчин	

ДӨРӨВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ

Өмнөх үе шатанд сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэх хуулийн төслийн зохицуулалтыг тухайн шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийг ашиглан хууль тогтоомжийн үр нөлөөг үнэлэх юм. Шалгуур үзүүлэлтийг дараах шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх болно.

Хүснэгт 3. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгсэл

Д/д	Шалгуур үзүүлэлт	Шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Зорилгод хүрэх байдлын дүн шинжилгээ хийх: Хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийн үзэл баримтлалд дурдсан хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэхэд дүн шинжилгээ хийнэ.
2	Практикт хэрэгжих боломж	Практикт хэрэгжих боломжийг шалгах: Хуулийн төслийн практикт хэрэгжих боломжийг аргачлалын 4.6-д заасан асуултад хариулах замаар шалгана.

Дээрх урьдчилан сонгож авсан шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төсөлд үр нөлөөний үнэлгээг дараах байдлаар хийв.

4.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төсөл боловсруулах болсон хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэхийг шалгах ба хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ шаардлагыг хуулийн төсөлд хэрхэн тусгасныг тогтоох, эдгээр зохицуулалт нь үзэл баримтлалд тодорхойлсон хэрэгцээ, шаардлагад нийцэж байгаа эсэхийг харьцуулан дүн шинжилгээ хийлээ.

Хуулийн төслийн 2 дугаар бүлэг. Өгөгдлийн дэд бүтцийг тодорхойлж, төрийн их өгөгдөл, өгөгдлийн санг мэдээллийн сангийн нэгдсэн ангилал, кодын дагуу үүсгэх, сангаас ашиглах зориулалтаас нь шалтгаалж өгөгдлийг ангилж, хүртээмжтэй ашиглуулах нөхцөлийг бүрдүүлсэн эсэх зорилгод хүрэх байдалд хийсэн дүн шинжилгээ

Хуулийн төслийн үзэл баримтлалд өгөгдлийн ангилал, өмчлөл, эзэмшил болон ашиглах эрхийг нэгдсэн байдлаар хуульчлан тодорхойлоогүй, төр, хувийн хэвшил, иргэн хооронд өгөгдөл солилцох, хамтран ашиглах, дахин ашиглах, арилжаалах, зуучлах эрх зүйн зохицуулалт бүрдээгүй, инновац, хиймэл оюуныг хөгжүүлэхэд шаардлагатай их өгөгдөл хангалтгүй, өгөгдлийг анхны зорилгоос өөрөөр дахин ашиглах нөхцөлийг зохицуулаагүйгээс өгөгдлийг эдийн засгийн эргэлтэд оруулах боломжгүй талаар дурджээ.

Хуулийн төсөлд “өгөгдөл”-тэй холбоотой ойлголтуудыг тодорхойлохдоо Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах замаар нээлттэй өгөгдөлтэй холбоотой зохицуулалтыг уг хуулийн үйлчлэх хүрээнээс гаргаж зохицуулсан, мөн хуулийн төслийн зорилго нь өгөгдлийн дэд бүтэц, эрх зүйн үндэсийг бий болгон өгөгдлийн чанар, аюулгүй байдал, хүртээмжтэй байдлыг хангах замаар өгөгдлийг эдийн засгийн эргэлтэд оруулахад чиглэж буй өргөн агуулгаар тодорхойлсон нь үзэл баримтлалаар дэвшүүлсэн зорилгод нийцэж байна.

Хуулийн төслийн “Өгөгдлийн дэд бүтэц, өгөгдлийн сан” гэх Хоёрдугаар бүлгийн 6 дугаар зүйлд “Төрийн их өгөгдлийн дэд бүтэц”, 7 дугаар зүйлд “Төрийн их өгөгдөл”, 8 дугаар зүйлд “Их өгөгдлийн сан болон өгөгдлийн сан үүсгэх, түүнд тавигдах шаардлага” зэргийг тодорхойлсон байна.

Хуулийн төслийн 6 дугаар зүйлд Монгол Улсын төрийн их өгөгдлийн дэд бүтэц байх бөгөөд уг дэд бүтэц нь төрийн их өгөгдөл, түүнийг хадгалах, боловсруулах систем болон мэдээллийн сүлжээний нэгдэл байхаар тусгажээ. Үүнээс гадна дээр дурдсан мэдээллийн системийн үйл ажиллагаа нь кибер аюулгүй байдлыг хангасан, үйл ажиллагааны бүртгэлийн системтэй байх зэрэг хэсгүүдтэй байхаар тодорхойлсон. Мөн уг төрийн их өгөгдлийн дэд бүтцэд холбогдох техникийн нөхцөл, шаардлагыг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлахаар заасан байна.

Хуулийн төслийн 7 дугаар зүйлд төрийн их өгөгдлийн системд хувийн өмчийн хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага, хүн сайн дурын үндсэн дээр мета өгөгдлийн нэгдсэн каталог, мэдээллийн сангийн нэгдсэн ангилал, код, стандартын дагуу өгөгдөл нийлүүлж болох талаар, мөн төрийн их өгөгдлийн системээс ашиглах өгөгдлийн ангилалыг тодорхойлсон байна. Түүнчлэн Засгийн газар төрийн их өгөгдлийн сангийн архитектурын хослолыг тодорхойлох, санг бүрдүүлэх, түүнд өгөгдөл нийлүүлэх, хадгалах, хамгаалах, ашиглах болон өгөгдлийн ангиллаас хамаарч эрх олгох журмыг батлахаар тусгажээ.

Харин хуулийн төслийн 8 дугаар зүйлээр их өгөгдлийн сан болон өгөгдлийн сан үүсгэх, түүнд тавигдах шаардлагыг тодорхойлсон байна. Тухайлбал, их өгөгдлийн болон өгөгдлийн үүсгэж болох этгээдийг зааж, эдгээр сангуудад тавигдах шаардлагыг тус тус тодорхойлсон байна.

Хуулийн төсөлд Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу тухайн хуулиар зохицуулвал зохих өгөгдлийн дэд бүтэц, их өгөгдлийн болон өгөгдлийн сан, тэдгээрт тавигдах шаардлагатай хамаарах асуудлын уялдааг хангаж, бүрэн тусгасан нь үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгод хүрэх боломжтой гэж үзэж байна.

Хуулийн төслийн 3 дугаар бүлэг. Өгөгдлийн амьдралын мөчлөг буюу өгөгдөл үүсгэх, цуглуулах, ангилах, боловсруулах, ашиглах, солилцох, дамжуулах, хадгалах, нөөцлөх, устгах харилцааг зохицуулсан эсэхэд хийсэн дүн шинжилгээ

Хуулийн төслийн үзэл баримтлалд Монгол Улсын Их Хурлаас 2021 онд баталсан Монгол Улсын Их Хурлаас 2021 онд цахим хөгжлийг дэмжих багц хуулиудыг баталсан нь өгөгдөлтэй холбоотой харилцааг зохицуулах суурь эрх зүйн орчныг бүрдүүлсэн чухал алхам болсон. Эдгээр хуулиар нийтийн мэдээллийн ил тод байдал, хүний хувийн мэдээлэл хамгаалах, кибер аюулгүй байдал, цахим гарын үсэг, цахим үйлчилгээний суурь зарчим, шаардлагыг тодорхой хэмжээнд зохицуулсан боловч практик хэрэгжилтийн түвшинд өгөгдлийг байгууллага, салбар, мэдээллийн систем хооронд солилцох, нэгтгэх, чанаржуулах, дахин ашиглах, өгөгдлийн бүтээгдэхүүн болгох, эдийн засгийн эргэлтэд оруулах, өгөгдлийн дэд бүтцэд хөрөнгө оруулалт татах харилцааг бүрэн хамарч чадаагүй талаар дурджээ.

Түүнчлэн өгөгдлийн бодлого, зохицуулалтын хүрээнд тулгамдаж буй асуудлыг тодорхойлох зорилгоор Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас 2026 онд төрийн болон хувийн хэвшлийн 75 байгууллагаас судалгаа авч, дүн шинжилгээ хийсэн. Уг судалгаагаар өгөгдөл солилцох, хуваалцах, ашиглах,

дахин ашиглах зохицуулалт дутмаг, төрийн байгууллагууд ижил төрлийн мэдээллийг давхардуулан цуглуулдаг, өгөгдлийг шинэчлэх давтамж зөрүүтэй, өгөгдлийн чанар, стандартыг баталгаажуулах тогтолцоо байхгүй, өгөгдөл солилцооны дэд бүтцийн харилцан уялдаа сул, өгөгдлийн аюулгүй байдал хангагдсан эсэх талаарх иргэн, байгууллагын итгэл сул хэмээн дүгнэгдсэн.

Иймд хуулийн төслийн Хоёрдугаар бүлэгт “Өгөгдлийн амьдралын мөчлөг”-тэй холбоотой харилцааг өгөгдлийг үүсгэхээс эхлэх устгах хүртлэх бүх үе шатыг хамруулан зохицуулсан болно. Тухайлбал, 9 дүгээр зүйлд “өгөгдөлд үүсгэх, цуглуулах, ангилах, боловсруулах”, 10 дугаар зүйлд “өгөгдөл ашиглах, нийтлэх”, 11 дүгээр зүйлд “өгөгдөл дамжуулах, солилцох”, 12 дугаар зүйлд “өгөгдлийг хадгалах, архивлах, нөөцлөх, устгах” үе шат бүрд тавигдах шаардлагыг тус тус хуульчилсан болно. Мөн хуулийн төслийн 10.4-т өгөгдөл, өгөгдөлд суурилсан бүтээгдэхүүнийг ашиглах тусгай нөхцлийн төрлийг тогтоож, уг тусгай нөхцлийн гэрээний жишиг загварыг Санхүү, төсвийн болон цахим хөгжил, инновац, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батлахаар, 11.5-д Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор дараах өгөгдлийг стратегийн ач холбогдол бүхий өгөгдлийг тодорхойлж, 11.6-д Стратегийн өгөгдлийг Монгол Улсын нутаг дэвсгэрт байршуулах бөгөөд уг өгөгдлийг хил дамнуулан дамжуулахад тагнуулын байгууллага болон кибер аюулгүй байдлын асуудал эрхэлсэн эрх бүхий байгууллагын зөвшөөрлийг авахаар, 11.7-д Хүний хувийн мэдээлэл агуулсан өгөгдлийг хил дамнуулан дамжуулахад Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль болон Монгол Улсын холбогдох бусад хууль тогтоомжид заасан аюулгүй байдлын шаардлагыг бууруулахгүй байхаар тус тус хуульчилсан байна.

Хуулийн эрх зүйн зохицуулалт нь орчин үед зөвхөн өгөгдлийг хамгаалах хүрээнд хязгаарлагдахгүйгээр, өгөгдлийн амьдралын мөчлөгийн бүх үе шат болох өгөгдөл үүсгэх, цуглуулах, ангилах, боловсруулах, хадгалах, хандах, дамжуулах, солилцох, ашиглах, архивлах, устгах үйл явцыг хамруулан цогц байдлаар зохицуулахаар байгаа нь үзэл баримтлалаар тогтоосон асуудлыг шийдвэрлэх зорилгод нийцэж байна.

Хуулийн төслийн 5 дугаар бүлэг. Өгөгдлийн харилцаанд оролцогч, тэдгээрийн бүрэн эрх, чиг үүргийг тодорхойлж, өгөгдлийн засаглалын тогтолцоог бэхжүүлэх эсэх зорилгод хүрэх байдалд хийсэн дүн шинжилгээ

Хуулийн төслийн “Өгөгдлийн засаглалын тогтолцоо” гэх Тавдугаар бүлгийн 16 дугаар зүйлд өгөгдлийн харилцаанд оролцогчид болох эзэмшигч, хариуцагч, боловсруулагч, нийлүүлэгч, зуучлагч, хэрэглэгч, кастодиан хэмээн ангилж, хуулийн төслийн 22-25 дугаар зүйлээр тэдгээрийн нийтлэг эрх, үүргийг хуульчилсан байна. Хуулийн төслийн 16.4-т “Хүн, хуулийн этгээд өөрийн үүсгэсэн, боловсруулсан, нэмүү өртөг шингээсэн өгөгдөл, өгөгдлийн бүтээгдэхүүнийг Иргэний хууль болон Оюуны өмчийн тухай хуульд заасан биет бус хөрөнгөд тооцон эдийн засгийн эргэлтэд оруулах, өмчлөх, ашиглах эрхтэй.” гэж, 18.1.5-д “өгөгдлийг эдийн засаг, бизнесийн эргэлтэд оруулах зорилгоор түүнийг биет бус хөрөнгө болгон үнэлэх, тайлагнахад мөрдөх үнэлгээний аргачлалыг батлахыг Засгийн газрын бүрэн эрхэд хамааруулах”-

аар тусгасан нь оюуны өмчийн эрхийн хамгаалалт болон итгэлцлийг бий болгоход ач холбогдолтой гэж үзэж байна.

Хуулийн төслийн 17 дугаар зүйлд өгөгдлийн засаглал, хөгжлийн талаарх нэгдсэн бодлого, стратеги, хөтөлбөр болон стратегийн өгөгдлийг хил дамнуулан дамжуулахад хяналт тавих нөхцлийг тогтоох, өгөгдлийн зэрэглэлийг тогтоохтой холбоотой баримт бичгийг батлахаар, мөн төрийн их өгөгдлийн дэд бүтцийг бүрдүүлэх, өргөтгөхөд шаардагдах санхүүжилтийг шийдвэрлэх бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр заасан байна. Хуулийн төслийн 18 дугаар зүйлд “өгөгдлийн засаглалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах, төрийн их өгөгдлийн дэд бүтцийг хөгжүүлэх стратеги, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, төрийн их өгөгдлийн дэд бүтцээр дамжуулан өгөгдөл солилцох, ашиглах, дамжуулах журмыг батлах, мөрдүүлэх, өгөгдөл зуучлалын үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдийг бүртгэх, тэдгээрт тавигдах шаардлагыг тогтоох асуудал”-ыг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхэд хамааруулахаар хуульчилжээ.

Түүнчлэн хуулийн төслийн 20 дугаар зүйлд Өгөгдлийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохицуулах, хяналт тавих чиг үүргийг Үндэсний статистикийн хороо хэрэгжүүлэхээр заасан байна. Харин мөн төслийн 21 дүгээр зүйлд Үндэсний дата төвийг төрийн их өгөгдлийн дэд бүтцийн тасралтгүй, найдвартай, аюулгүй ажиллагааг хангах, өгөгдөл хадгалах, нөөцлөх, боловсруулах, төрийн их өгөгдлийн дэд бүтцийг хариуцагч байгууллага байхаар тус тус тусгажээ.

Дээрх зохицуулалтуудаас харахад өгөгдлийн харилцаанд оролцогч талуудыг нарийвчлан тодорхойлсон хэдий ч өгөгдлийн ямар үе шатанд харилцаанд орохоос шалтгаалан нийтлэх эрх, үүргүүд давхардахаар байна.

Хуулийн төсөлд Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу тухайн хуулиар зохицуулвал зохих өгөгдлийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгаж, өгөгдлийн засаглалын тогтолцоог цогцоор нь бодлого, зохицуулалт, хэрэгжилтийг хангахтай холбоотой зохион байгуулалтын шинжтэй бусад асуудлыг зохицуулсан нь үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгод хүрэх боломжтой гэж үзэж байна.

4.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

Энэ хэсэгт Өгөгдлийн тухай хуулийн төслийн зохицуулалт нь шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломж байгаа эсэхийг, мөн хэрэгжүүлэх субъект, байгууллага нь хэн байх вэ гэдгийг тогтоох, тэдгээр байгууллагад тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо байгаа эсэхийг урьдчилан үнэллээ.

Уг үнэлгээний зорилго нь төрийн их өгөгдлийн дэд бүтэц, түүний засаглал, шаардлагыг тодорхойлсон хууль эрх зүйн шинэ зохицуулалтууд нь Монгол Улсын өнөөгийн практик хэрэгжих боломжтой эсэх, төр болон хуулийн этгээдэд үүсэх санхүүгийн болон захиргааны ачааллыг урьдчилан тогтоож, эрсдэлийг бууруулах зөвлөмж боловсруулахад оршино.

Хуулийн төслийг практик дээр турших нь тухайн зохицуулалт практикт хэрэгжих боломжтой эсэх, хуулийг хэрэгжүүлэх байгууллагууд түүнийг хүлээн

зөвшөөрч байгаа эсэх, бусад этгээдэд хэрхэн нөлөөлж байгаа болон тухайн зохицуулалтад байгаа хийдэл, дутагдалтай зүйлийг тогтооход чухал ач холбогдолтой хэдий ч энэ нь маш их цаг хугацаа, хүн хүч, зардал шаардах тул одоо болж байгаа үйл явц, хуулийн зохицуулалтад дүн шинжилгээ хийх замаар боловсруулсан. Ингэхдээ дараах хоёр асуултад хариулах байдлаар тус шалгуур үзүүлэлтийг үнэлсэн.

1.Хуулийн төслийг хэрэгжүүлэх субъект байгаа эсэх;

2.Хуулийн төслийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж бололцоо байгаа эсэх.

Хуулийн төслийн 2 дугаар бүлэгт тусгасан зохицуулалтын практикт хэрэгжих боломжид хийсэн дүн шинжилгээ
--

4.2.1.Хэрэгжүүлэх субъект байгаа эсэх

Хуулийн төслийн 6 дугаар зүйлд Монгол Улс төрийн их өгөгдлийн дэд бүтэцтэй байхаар, 7 дугаар зүйлд төрийн их өгөгдөл бий болгох харилцааг, 8 дугаар зүйлд их өгөгдлийн сан болон өгөгдлийн сан үүсгэх, түүнд тавихгдах шаардлагыг заасан нь уг зохицуулалтын хэрэгжилтийг хангах суурь эрх зүйн үндсийг бүрдүүлсэн.

Уг зохицуулалтыг хэрэгжүүлэх эрх зүйн болон бүтцийн субъектүүд Монгол Улсад бодитоор оршин байгаа боловч тэдгээрийн чиг үүргийн хуваарилалт, ачаалал даах чадамж харилцан адилгүй байна.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлээр нийтийн мэдээллийн сан нь суурь мэдээллийн сан, төрөлжсөн мэдээллийн сан, байгууллагын мэдээллийн сангаас бүрдэхээр заасан бөгөөд уг сангуудаас мэдээллийг нэгтгэн нийлүүлэх, мөн энэ хуулиар тодорхойлоогүй бусад мэдээллийн эзэн, мэдээлэл хариуцагч хооронд өгөгдлийг аюулгүй, найдвартай, харилцан уялдаатай солилцох, ашиглах, дахин ашиглуулах нөхцөлийг бүрдүүлсэн мэдээллийн систем, мэдээллийн сүлжээний нэгдэлийг төрийн их өгөгдлийн дэд бүтэц гэж тодорхойлсон.

Уг дэд бүтэц нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.1-д заасан нийтийн мэдээллийн дэд бүтцэд хамааруулахаар заасан тул төрийн төвлөрсөн удирдлагын субъект нь Цахим хөгжил, инноваци, харилцаа холбооны яам (Бодлого тодорхойлогч), Үндэсний дата төв (Дэд бүтэц хариуцагч), Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар (Хэрэгжүүлэгч) нь энэ зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх үндсэн субъектүүд мөн.

Харин уг дэд бүтцэд өгөгдөл нийлүүлэгч салбар субъектүүд нь нийтийн мэдээллийн сан хариуцагч байгууллагууд (Улсын бүртгэлийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар гэх мэт) болон хувийн хэвшлийн аж ахуй нэгжүүд байх талаар хуулийн төслийн 7.2-т тодорхойлсон байна.

Хуулийг хэрэгжүүлэх төрийн байгууллагууд (яам, агентлаг) бэлэн байгаа, түүнчлэн төрийн их өгөгдөл, түүнийг хадгалах, боловсруулах системийн хэюийн

найдвартай ажиллагааг хангах байгууллага (Үндэсний дата төв) байгаа боловч их өгөгдлийн сангаас өгөгдлийг ашиглуулахтай холбогдсон харилцаанд хяналт тавих этгээд тодорхойгүй байна.

4.2.2. Зохицуулалтыг практикт хэрэгжүүлэх боломж бололцоо байгаа эсэх

Хуулийн төслийг практикт шууд хэрэгжүүлэх боломж бололцоог “технологи” болон “эрх зүйн зохицуулалт”-ын хүрээнд үнэллээ.

Хуулийн заалт	Хэрэгжүүлэгч субъект	Шаардлагатай нөөц / Бэлэн байдал	Эрсдэл, практик саад бэрхшээл
6.1-6.2 (Төрийн их өгөгдлийн дэд бүтэцтэй байх, харилцан солилцох)	ЦХИХХЯ, Үндэсний дата төв, төрийн бүх байгууллага	Төвлөрсөн дата төвийн хүчин чадлыг өргөтгөх, сервер, клаудын зардал шаардлагатай.	Байгууллагуудын системийн хөгжүүлэлт өөр (Legacy системүүд). Харилцан уялдаа хангахад хугацаа их орно.
6.5.3 (Өгөгдлийн нэгдсэн каталог, мета өгөгдлийн бүртгэл)	Үндэсний статистикийн хороо, ЦХИХХЯ, төрийн бүх байгууллага	Мета өгөгдлийн нэгдсэн стандарт, каталогийн систем хөгжүүлэх инженерүүд	Байгууллагууд өөрийн өгөгдлийг ангилж, мета дата үүсгэх тал дээр арга зүйн болон хүний нөөцийн чадавх сул.
6.6 (Техникийн нөхцөл, шаардлагыг сайд батлах)	Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн сайд	Сайдын тушаалаар батлагдах журмын төслийг боловсруулах ажлын хэсэг	Журам батлагдах хүртэл хуулийн заалт практикт хэрэгжихгүй гацах эрсдэлтэй.
7.2-7.3 (Өгөгдөл нийлүүлэх, мета өгөгдлийн стандарт мөрдөх)	Төрийн мэдээллийн сан хариуцагч байгууллагууд, хувийн хэвшил	Байгууллага бүрд өгөгдлийн сангийн бүтэц, мета өгөгдлийг стандартад шилжүүлэх ETL (Extract, Transform, Load) инженерүүд шаардлагатай.	Төрийн байгууллагуудын дата чанар (Data quality) муу, ангилал, код стандарт зөрдөг. Хувийн хэвшилд өгөгдөл сайн дураар өгөх практик сонирхол бага.
7.4 (Өгөгдөл солилцооны дундын систем ашиглах)	Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, Үндэсний дата төв.	Их хэмжээний өгөгдлийг багцлан дамжуулах өндөр хурдны сүлжээ, технологийн платформ (Бэлэн байдал дунд).	"Их өгөгдөл" (Big Data) дамжуулахад техникийн хувьд ачаалал нэмэгдэх тул дэд бүтцийг өргөтгөх шаардлагатай.
7.5-7.6 (Өгөгдлийг	ЦХИХХЯ, ТЕГ,	Машин унших	Нууц (7.5.3) болон

ангилах, машин хэлбэрээр солилцох)	API-аар унших	ХЭҮК, эзэмшигч байгууллагууд	Өгөгдөл	боломжтой API хөгжүүлэлтийн нэгдсэн удирдлагын систем (API Gateway).	хүний эмзэг мэдээллийг (7.5.2) машин унших хэлбэрт оруулж, API-аар солилцох нь мэдээлэл алдагдах, халдлагад өртөх өндөр эрсдэлтэй тул хяналт тавих этгээдийг бүрэн чадамжтай байдлаар хуульд тусгах шаардлагатай.
7.7-7.8 (Төвлөрсөн, тархмал архитектур, Засгийн газрын журам батлах)		Монгол Засгийн ЦХИХХЯ	Улсын газар,	Журмын төсөл боловсруулах салбар дундын ажлын хэсэг. Техникийн архитектурын зураглал.	Журам батлагдах хүртэл архитектур тодорхойгүй байх тул төрийн байгууллагууд хөрөнгө оруулалт, системийн хөгжүүлэлтээ хийж чадахгүй хүлээлтийн байдалд орно.
8.1 - 8.2 (Өгөгдлийн сан үүсгэх эрх, 9 төрлийн мета өгөгдлийн бүртгэл хөтлөх)		Өгөгдлийн сан үүсгэгч төр, хувийн хэвшлийн хуулийн этгээд, иргэд		Мета датаг удирдах програм хангамж, үйл ажиллагааг гардан гүйцэтгэх дата засаглалын мэргэжилтнүүд	Технологийн хувьд боломжтой ч жижиг, дунд компаниуд болон төрийн доод шатны байгууллагуудад өдөр тутамдаа мета өгөгдөл шинэчлэх практик боломж сул (ажлын ачаалал ихсэнэ).
8.3.1 - 8.3.3 (Давтагдашгүй түлхүүр талбар ашиглах, урт хугацаанд тогтвортой хэрэглэх)		Төрийн мэдээллийн сан хариуцагч байгууллагууд, системийн архитекторууд		Нэгдсэн кодын ангилал, систем хоорондын уялдааг хангах хөгжүүлэлтийн санхүүжилт	Төрийн одоогийн системүүд (Legacy системүүд) хоорондоо нэгдсэн түлхүүр талбаргүй.
8.4 (Гадаадын болон дотоодын дата төвд өгөгдөл байршуулах)		Дата төвүүд		Клауд түрээсийн тогтмол төсөв, мэдээллийн аюулгүй байдлын хараат бус аудитын үнэлгээний систем	Дэлхийн шилдэг клауд (AWS, Google, Azure) дэд бүтцийг ашиглах маш өндөр технологийн боломжийг нээж өгсөн.
8.5		Төрийн		Дундын датаг	Хамтран үүсгэсэн

(Төр, хувийн хэвшил хамтран дундын өгөгдлийн сан үүсгэх)	байгууллагууд болон бизнесийн хуулийн этгээдүүд хамтран.	удирдах платформ.	дата сангийн оюуны өмч, өгөгдлийг эзэмших, ашиглах эрхийг (Data ownership) хэрхэн хуваарилах практик эрх зүйн зохицуулалт, боломжийг нэмж зохицуулах шаардлагатай.
--	--	-------------------	--

Одоогийн төрийн мэдээлэл солилцооны “ХУР” систем нь багц их өгөгдлийг дамжуулах, боловсруулах зориулалтгүй тул хуулийн 7.4-т заасан дундын системийг шинээр шийдвэрлэх, төрийн байгууллагуудын хүний нөөц, стандартын бэлэн байдлыг харгалзан хуулийг дагаж мөрдөх хугацааг 2-3 жилийн шилжилтийн үетэйгээр тогтоох шаардлагатай байна.

Мөн сайн дураараа өгөгдлөө нийлүүлсэн этгээдэд төрийн их өгөгдлийн сангийн нээлттэй өгөгдлийг давуу эрхтэй, үнэгүй ашиглах эрх олгох замаар тэдгээрийн гаргасан зардлыг (5.2) нөхөх эдийн засгийн хөшүүрэг тусгах нь хуулийн үр нөлөөг нэмэгдүүлэх чухал алхам болно.

Хуулийн төслийн 6, 7 дугаар зүйлийг хэрэгжүүлэхэд төрд эхний жилдээ өндөр хөрөнгө оруулалтын ачаалал үүсэх хэдий ч дунд хугацаандаа (3-аас дээш жил) төрийн байгууллагуудын давхардсан зардлыг асар их хэмжээгээр бууруулж, өөрийгөө нөхөх бүрэн боломжтой байна.

Хуулийн төслийн 4 дүгээр бүлэгт тусгасан зохицуулалтын практикт хэрэгжих боломжид хийсэн дүн шинжилгээ

4.2.1.Хэрэгжүүлэх субъект байгаа эсэх

Хуулийн төслийн Дөрөвдүгээр бүлгээр зохицуулах харилцаа нь Монгол Улсыг бүс нутгийн дата хаб (Data Hub) болгох, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах маш стратегийн чухал зохицуулалтууд агуулсан байна.

Хуулийн заалт	Хэрэгжүүлэгч субъект	Шаардлагатай нөөц / Бэлэн байдал	Эрсдэл, практик саад бэрхшээл
13.1 - 13.2.1 (Дотоод, гадаадын этгээд дата төв ажиллуулах, эрчим хүчний 1-р зэрэглэлд хамруулах)	Эрчим хүчний яам, Үндэсний диспетчерийн үндэсний төв, ЦХИХХЯ.	Эрчим хүчний нэгдсэн сүлжээний найдвартай эх үүсвэр, хоёрдогч шугам татах дэд бүтэц.	Дата төвүүдийг шууд 1-р зэрэглэлийн (тасралтгүй) тэжээлээр хангах практик техникийн нөөц туйлын хомс.
13.2.2 - 13.2.6 (Холбооны сүлжээ, радио давтамж,	Харилцаа холбооны зохицуулах хороо (ХХЗХ), Эрчим	Тусгай зөвшөөрөл, радио давтамж олгох үйл	

сэргээгдэх эрчим хүчний зөвшөөрлийг саадгүй олгох)	хүчний зохицуулах хороо (ЭХЗХ).	ажиллагааны журмыг хөнгөвчлөх эрх зүйн бэлэн байдал.	
13.2.7 (Чөлөөт бүсээс бусад байршилд Чөлөөт бүсийн татвар, хөрөнгө оруулалтын хөнгөлөлт эдлэх)	Сангийн яам, Татварын ерөнхий газар (ТЕГ), Гаалийн ерөнхий газар, Чөлөөт бүсийн захирагч	Татварын тусгай дэглэмийн бүртгэл, хяналтын цахим систем.	
13.3 - 13.6 (Гадаадын өгөгдлийн халдашгүй байдал, тусгай албад хандахыг хориглох, үл үйлчлэх нөхцөл)	Гадаад харилцааны яам, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам	Олон улсын эрх зүйн туслалцаа үзүүлэх хэлэлцээрүүд	Үндэсний аюулгүй байдалд халдсан кибер халдлага гадаадын дата төвөөс чиглэсэн тохиолдолд дотоодын тусгай албад шууд хандаж чадахгүй уях эрсдэлтэй.
13.7 - 13.9 (Транзит урсгалын халдашгүй байдал, хяналт хийхгүй байх, дипломат статус олгох)	Гадаад харилцааны яам, Засгийн газар	Хөрш орнууд (ОХУ, БНХАУ) болон гуравдагч улсуудтай хийх тусгайлсан олон улсын гэрээ, хэлэлцээрийн төслүүд.	Транзит өгөгдлийг өөрийн нутаг дэвсгэрээр гаргахдаа хяналт тавихгүй байх тусгайлсан хэлэлцээрийг хөрш орнуудтай тохироход геополитикийн өндөр саад тулгарна.
13.10 (Интернэтийн гарцыг бие даасан 3-аас доошгүй байхаар зохион байгуулах)	ЦХИХХЯ, Мэдээлэл холбооны сүлжээ ТӨК, хувийн үүрэн холбоо, интернэтийн операторууд	Шинэ гарц байгуулах хөрөнгө оруулалт (Шилэн кабель, нам орбитын хиймэл дагуулын станц), ТЭЗҮ.	Монгол Улс газар зүйн хувьд зөвхөн хоёр хөршөөс хамааралтай интернэтийн гол гарцтай. Гуравдагч бие даасан гарцыг техникийн хувьд (жишээ нь, сансрын интернэтээр бүрэн хэмжээний дата төвийн багтаамж хангах) шийдвэрлэхэд техникийн болон геополитикийн хязгаарлалттай.

<p>13.11 - 13.12 (Газар, барилга, эрчим хүчний хүсэлтийг Нэг цонхоор авах, ЦХИХХЯ хариуцах)</p>	<p>Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар</p>	<p>Нэг цонхны цахим систем, салбар дундын мэдээлэл солилцох интеграци.</p>	<p>Газар олголт (Газрын тухай хууль), барилгын зөвшөөрөл (Барилгын тухай хууль), эрчим хүчний техникийн нөхцөл (Эрчим хүчний тухай хууль) тус бүрдээ өөр өөр яам, орон нутгийн байгууллагын хуулиар хамгаалагдсан чиг үүрэг байдаг. Дагалдах хуулиар эдгээр эрхийг ЦХИХХЯ-нд төвлөрүүлээгүй тул нэг цонх нь практикт зөвхөн "зуучлах" хэлбэртэй болж, шийдвэрлэлт гацах эрсдэлтэй.</p>
<p>13.14 (Үр өгөөжийн хэмжүүр, шалгуур үзүүлэлтийг Засгийн газар батална)</p>	<p>Засгийн газар, ЦХИХХЯ</p>	<p>Эдийн засаг, технологи, хүний нөөцийн үр өгөөжийг хэмжих аргачлал, KPI үзүүлэлтүүд.</p>	<p>Засгийн газрын тогтоолоор батлагдах үзүүлэлтүүд хэт өндөр эсвэл практик амьдралаас тасархай тогтоогдвол гадаадын томоохон хөрөнгө оруулагчид (AWS, Microsoft гэх мэт) Монголд орж ирэх сонирхолгүй болно.</p>
<p>15.1 - 15.2 (Төрийн өгөгдлийг дотоодод хадгалах, шаардлагатай бол гадаадад байршуулах олон улсын гэрээ байгуулах)</p>	<p>Монгол Улсын Засгийн газар, ЦХИХХЯ, Гадаад харилцааны яам</p>	<p>Төрийн өгөгдлийг гадаадын клаудад байршуулах олон улсын гэрээний төслүүд, эрсдэлийн үнэлгээний баг.</p>	<p>Гадаадад өгөгдөл байршуулах (15.2) гэрээ байгуулах процесс нь дипломат харилцаа болон Үндэсний аюулгүй байдлын үүднээс маш урт хугацаа шаардаж, шууд хэрэгжих боломж удааширна.</p>
<p>15.3 - 15.4 (Хил дамнасан өгөгдлийн шинэ)</p>	<p>ЦХИХХЯ, Харилцаа холбооны зохицуулах хороо,</p>	<p>Сэндбокс орчныг удирдах, хяналт тавих техникийн</p>	<p>Технологийн "Сэндбокс" нь хуулиар</p>

технологид зориулж "Сэндбокс" орчин бий болгох, журам батлах)	Шинэ технологи турших хуулийн этгээдүүд	платформ, Засгийн газрын тусгай журам	зөвшөөрөгдөөгүй шинэ шийдлийг турших боломж олгодог тул туршилтын явцад хэрэглэгчийн болон төрийн дата гадагшаа алдагдах, кибер халдлагад өртөх бодит эрсдэлтэй.
---	---	---------------------------------------	--

4.2.2.Зохицуулалтыг практикт хэрэгжүүлэх боломж бололцоо байгаа эсэх

1. Төрийн төвлөрсөн зохицуулагч субъект ба засаглалын чадамжийн тухайд

Хуулийн төслийн 13.11, 13.12 болон 15.4 дүгээр заалтад тусгагдсан дэд бүтцийн “Нэг цонхны үйлчилгээ”-г зохион байгуулах, олон улсын дата төв эрхлэгчтэй хөрөнгө оруулалтын хэлэлцээр хийх, түүнчлэн технологийн зохицуулалтын туршилтын орчин (Сэндбокс)-ийг ажиллуулж, хяналт тавих үндсэн субъект болох цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Монгол Улсын засаглалын бүтцэд бодитоор оршин байна. Гэвч хуулийн төслийн 13.13 дугаар хэсэгт олон улсын дата төв эрхлэх хүслэгт гаргасан этгээдтэй “харилцан тохиролцож” гэрээ байгуулахаар заасан нь эрх зүйн хэт өндөр давуу эрх олгохоор байна. Энэ нь Засгийн газрын тогтоолоор батлагдах үр өгөөжийн хэмжүүр, шалгуур үзүүлэлт (13.14) болон сэндбоксын хяналтын журам (15.4) эцэслэгдэн батлагдах хүртэл тухайн субъект бие даан шийдвэр гаргаж чадахгүй практик гацаа үүсэх, үйл ажиллагаа удаашрах эрсдэлийг дагуулж байна.

2. Салбар дундын төрийн субъектүүдийн уялдаа холбооны тухайд

Дата төвийн үйлчилгээг цогцоор нь эрхлэхэд шаардлагатай газар олгох, барилга барих, эрчим хүчний техникийн нөхцөл олгох болон харилцаа холбооны сүлжээгээр хангах (13.11) үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэгч бодит субъектүүд нь Эрчим хүчний яам, Барилга, хот байгуулалтын яам болон Орон нутгийн засаг захиргаа, газрын албад юм. “Нэг цонхны үйлчилгээ”-гээр хүсэлт хүлээн авах хэдий ч бусад салбарын яам, орон нутгийн байгууллагуудыг хугацааны хувьд шахаж ажиллуулах, тэдний бие даасан шийдвэрт нөлөөлөх засаглалын бодит эрх мэдэл, эрх зүйн чадамжаар дутмаг байна.

Иймд дээрх дээрх эрсдэлийг бууруулж, харилцааг бодитоор хөнгөвчлөхийн тулд хуулийн төслийн 13.11 дүгээр хэсэгт нэг цонхоор ирсэн хүсэлтийг салбарын яамд болон орон нутгийн байгууллагууд нийтлэг журмаас 2 дахин богино хугацаанд, дараалал харгалзахгүйгээр давуу эрхээр шийдвэрлэх процессын зохицуулалтыг

нэмэлтээр зааж, хуулийг хэрэгжүүлэх салбар дундын хамтарсан Ажлын хэсгийг Засгийн газрын шийдвэрээр байгуулахаар үүрэгжүүлэх шаардлагатай байна.

Мөн гуравдагч бие даасан гарцыг газар зүйн хувьд байгуулахад манай улс зөвхөн хоёр хөрштэй хиллэдэг практик хязгаарлалттай тул 13.10-т “нам орбитын болон геостационар харилцаа холбооны хиймэл дагуулын сүлжээний технологид суурилсан...” гэж тодотгож өгөх нь хэрэгжих практик боломжийг техникийн хувьд нээж өгөхөөр байна.

Хуулийн төслийн 15 дугаар зүйл болох “Хил дамнасан өгөгдлийн урсгал, технологийн зохицуулалтын туршилтын орчин” нь төрийн өгөгдлийн бүрэн бүтэн байдал, цахим тусгаар тогтнолыг хамгаалахын зэрэгцээ технологийн шинэлэг шийдлүүдийг дэмжих зохицуулалтын уян хатан орчин буюу Сэндбокс (Regulatory Sandbox)-ыг Монгол Улсад анх удаа мэдээллийн технологийн салбарт эрх зүйн хувьд нээж өгч байгаагаараа маш чухал ач холбогдолтой байна.

ТАВ. ҮР ДҮНГ ҮНЭЛСЭН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

5.1. Үр дүнг баримтжуулах

Өгөгдлийн тухай хуулийн төсөлд үр нөлөөний үнэлгээ хийж, зорилгод хүрсэн эсэх, хэрэгжүүлэгч талуудад хүлээн зөвшөөрөгдөх эсэх зэргийг судлахдаа холбогдох хэд хэдэн хуулиас гадна дараах нэмэлт баримт бичиг, бусад материалыг ашигласан болно. Үүнд:

5.1.Хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл, түүний танилцууллага;

5.2.Хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгаа;

5.3.Хуулийн төсөлтэй холбогдуулан гаргасан энэ чиглэлийн үйлчилгээ эрхэлж байгаа хуулийн этгээдүүдээс гаргасан санал.

Өгөгдлийн тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг холбогдох шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн бөгөөд холбогдох хууль тогтоомж, бусад эрх зүйн акт болон хамаарал бүхий холбогдох мэдээлэл зэрэг бусад материалыг ашиглаж, ашигласан материалын жагсаалтыг үнэлгээний тайланд хавсаргаснаас гадна үнэлгээ хийсэн хуулийн төслийг хавсаргасан болно.

5.2. Үнэлэх

Хуулийн төсөлтэй холбоотой санал, дүгнэлтийг шалгуур үзүүлэлт бүрийн хэсэгт тодорхой дэлгэрэнгүй бичсэн бөгөөд түүнийг дараах байдлаар хураангуйлан тоймлож байна.

Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтээр:

Хуулийн төслийн зорилго, зорилт нь хуулийн төслийг боловсруулах болсон хэрэгцээ шаардлага, үндэслэлүүдтэй нийцэж байгаа болон үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгыг бүрэн илэрхийлж чадсан эсэхэд үнэлгээ хийж үзлээ.

Энэ хүрээнд үзэл баримтлалд тодорхойлсон өгөгдлийн дэд бүтцийг тодорхойлж, төрийн их өгөгдөл, өгөгдлийн санг мэдээллийн сангийн нэгдсэн ангилал, кодын дагуу үүсгэх, сангаас ашиглах зориулалтаас нь шалтгаалж өгөгдлийг ангилж, хүртээмжтэй ашиглуулах нөхцөлийг бүрдүүлэх, өгөгдлийн амьдралын мөчлөг буюу өгөгдөл үүсгэх, цуглуулах, ангилах, боловсруулах, ашиглах, солилцох, дамжуулах, хадгалах, нөөцлөх, устгах харилцааг зохицуулах, Өгөгдлийн харилцаанд оролцогч, тэдгээрийн бүрэн эрх, чиг үүргийг тодорхойлж, өгөгдлийн засаглалын тогтолцоог бэхжүүлэх гэсэн зорилтыг хуулийн төсөлд хэрхэн томъёолсон, тухайн харилцаанд хамаарах бүх асуудлыг бүрэн хамарч зохицуулсан эсэхийг тодорхойлохыг зорьлоо.

Дээрх зорилтуудын хүрээнд хуулийн төсөлд тусгавал зохих харилцаануудыг олон улсын туршлага, практикт тулгамдаад байгаа бэрхшээлүүдийг харгалзан өөрийн орны онцлогт тохируулан үзэл баримтлалаар тодорхойлсон шаардлагад нийцүүлэн оновчтойгоор тодорхойлсон гэж дүгнэж байна. Тухайлбал, Хуулийн төслийн 2 дугаар бүлэгт төрийн их өгөгдлийн дэд бүтцийн бүрдлийг тодорхойлж, төрийн их өгөгдөл болон их өгөгдлийн санг үүсгэх зохицуулалтыг тусгаж, шаардлагыг хуульчилсан. Мөн хуулийн төслийн 3 болон 5 дугаар бүлэгт өгөгдлийн

амьдралын мөчлөг буюу өгөгдлийн бүх үе шат, өгөгдөлд оролцогч талуудыг нарийвчлан тодорхойлсон нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу тухайн хуулиар зохицуулвал зохих өгөгдлийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгаж, өгөгдлийн засаглалын тогтолцоог цогцоор нь бодлого, зохицуулалт, хэрэгжилтийг хангахтай холбоотой зохион байгуулалтын шинжтэй бусад асуудлыг зохицуулсан нь үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгод хүрэх боломжтой гэж үзэж байна.

Практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтээр:

Уг хуулийг хэрэгжүүлэх төрийн байгууллагууд, Мэдээллийн технологийн нэгдсэн холбоо, ДАМА Монголиа Чаптер-Монголын дата менежментийн мэргэжлийн холбоодын төлөөлөл хамтран ажилласан байгаа нь хуулийн төслийн зохицуулалтын практикт хэрэгжих байдлыг бодит болгосон байна.

Хуулийн төсөлд туссан зохицуулалтууд хэрэгжиж эхэлснээр төр, хувийн хэвшил, иргэн хооронд өгөгдлийг хуульд нийцүүлэн, аюулгүй солилцох, дахин ашиглах нөхцөл бүрдэж, өгөгдлийн ангилал, эзэмшил, ашиглалтын эрх, оролцогч талуудын хариуцлага тодорхойлогдон, өгөгдлийн засаглал сайжирч, өгөгдөл, мэдээллийг давхардуулан цуглуулах болон мэдээллийн зөрүү буурч, төрийн үйлчилгээний уялдаа холбоо, үр ашиг нэмэгдэж, өгөгдлийн аюулгүй байдал, нууцлал, хяналт, аудитын тогтолцоо боловсронгуй болж, иргэн, хуулийн этгээдийн итгэл нэмэгдэхээс гадна олон улсын жишигт нийцсэн зохицуулалт бүрдсэнээр хил дамнасан өгөгдөл ашиглалт, дижитал хамтын ажиллагааны эрх зүйн орчин бэхжихээр байна.

Мөн Монгол Улсад хамаарахгүй өгөгдлийн халдашгүй байдал (data sovereignty)-ыг үндэсний аюулгүй байдал, кибер хамгаалалт, мэдээллийн тусгаар тогтнолын хүрээнд хуульчлан баталгаажуулж, стратегийн өгөгдлийг хамгаалах тусгай дэглэм тогтоосноор олон улсын дата төвүүд байгуулагдан Төв Ази, Зүүн хойд Азийн бүсийн өгөгдлийг хадгалах, дамжуулах “Дата тээвэр ба хадгалалт”-ын үйлчилгээний экспортын шинэ орлогын эх үүсвэр нээгдэж байна.

Хил дамнасан өгөгдлийн урсгал, технологийн зохицуулалтын туршилтын орчин нь төрийн өгөгдлийн бүрэн бүтэн байдал, цахим тусгаар тогтнолыг хамгаалахын зэрэгцээ технологийн шинэлэг шийдлүүдийг дэмжих зохицуулалтын уян хатан орчин буюу Сэндбокс (Regulatory Sandbox)-ыг Монгол Улсад анх удаа мэдээллийн технологийн салбарт эрх зүйн хувьд нээж өгч байгаагаараа маш чухал ач холбогдолтой байна.

Түүнчлэн хуулийн төсөл боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хуулийн төсөлд тавигдах нийтлэг шаардлагад нийцсэн байх тул дор дурдсан нэмэлт зохицуулалтыг хийж, хуулийн төслийг хэвээр хадгалах нь зүйтэй байна.

5.3. Зөвлөмж өгөх

Хуулийн төслийн үр нөлөөг тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэх явцад анхаарах шаардлагатай, хуулийн төслийг боловсронгуй болгох, чанарыг сайжруулвал зохих дараах зохицуулалтын талаар зөвлөмж боловсруулан хууль санаачлагчид өгч байна. Үүнд:

1. Төрийн бүх байгууллага шууд мета өгөгдлийн каталог (6.5.3) хөтлөх боломжгүй тул яам, агентлаг, орон нутаг гэсэн үе шаттайгаар дагаж мөрдөх хугацааг хуулийн төслийн төгсгөлд (Дагаж мөрдөх журмын тухай хууль) зааж өгөх;
2. Нэг цонхоор ирсэн хүсэлтийг салбарын яамд болон орон нутгийн байгууллагууд нийтлэг журмаас 2 дахин богино хугацаанд, дараалал харгалзахгүйгээр давуу эрхээр шийдвэрлэх процессын зохицуулалтыг нэмэлтээр зааж өгөх;
3. Хуулийн төслийн 17.1.5-д “өгөгдлийг эдийн засаг, бизнесийн эргэлтэд оруулах зорилгоор түүнийг биет бус хөрөнгө (Intangible assets) болгон үнэлэх, тайлагнахад мөрдөх үнэлгээний аргачлалыг Засгийн газар батлах;” гэж заасныг Хөрөнгийн үнэлгээний тухай хуультай нийцүүлж, зохицуулалтыг зөрчил үүсгэхгүй байхаар тусгах.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д хуульчилсан “Хууль санаачлагч нийгмийн харилцааны төлөв байдал, тулгамдсан асуудлыг судалсны үндсэн дээр шинээр үүссэн харилцааг хуулиар зохицуулах шаардлагатай, эсхүл тухайн нийгмийн харилцааны эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан шинэ хуулиар зохицуулах шаардлагатай гэж үзвэл анхдагч хуулийн төсөл боловсруулна” гэсэн хэм хэмжээг зөрчөөгүй байна гэсэн нэгдсэн дүгнэлт хийв.

---o0o---

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Нэг. Хууль тогтоомжийн жагсаалт

- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Иргэний хууль
- Хууль тогтоомжийн тухай хууль
- Харилцаа холбооны тухай хууль
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль
- Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль
- Кибер аюулгүй байдлын тухай хууль
- Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль
- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль
- Чөлөөт бүсийн тухай хууль
- Зөрчлийн тухай хууль

Хоёр. Монгол Улсын Их Хурлын тогтоол

- “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, 2020
- “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай”, Монгол Улсын Их Хурлын 2025 оны 109 дүгээр тогтоол, 1 дүгээр хавсралт
- Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2020

Гурав. Монгол Улсын Засгийн газрын тогтоол

- Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт
- Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 403 дугаар тогтоол
- Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 18 дугаар хуралдааны тэмдэглэл

Дөрөв. Ашигласан мэдээлэл, судалгаа, гарын авлага

- Өгөгдлийн тухай анхдагч хуулийн төсөл, 2026
- Өгөгдлийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл
- Өгөгдлийн тухай хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааны тайлан, 2026

Тав. Интернэт эх сурвалж

- www.legalinfo.mn

---oOo---